



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТЭС



*Нийслэлд хэрэгжсэн
авто замын гүүр, гүүрэн
байгууламж, нүхэн
гарцтай холбоотой
төсөл арга хэмжээний
хэрэгжилт, үр дүн*

УЛААНБААТАР ХОТ
2024 он



Нэг. Ерөнхий мэдээлэл

**Аудитын
код:**

НТАГ-
НТАГ-2024/27-ШТА-ГА

**Шалгагдсан
байгууллага, нэгжийн нэр:**

**НЗДТГ, НЗХГ, НХОГ ОНӨААТҮГ, НӨХГ,
дүүргүүдийн ЗДТГ, холбогдох бусад байгууллага**

**Аудитын
нэр:**

**Нийслэлд хэрэгжсэн авто замын гүүр, гүүрэн байгууламж,
нүхэн гарцтай холбоотой төсөл арга хэмжээний
хэрэгжилт, үр дүн**

**Аудит хийсэн бүтцийн
нэгжийн нэр:**

**Гүйцэтгэл-нийцлийн аудитын
хэлтэс**





Хоёр. Аудитын үр дүн:

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь нэмэлт санхүүжилт шаардагдах, ТАХ удаашрах үндэслэл болжээ.



2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Аудитын зорилт: Нийслэлд хэрэгжсэн авто замын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцтай холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: Авто замын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцын төсөл, арга хэмжээний төлөвлөлт оновчтой байна уу? Төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?



Аудитын хамарсан хүрээ:

Аудитад НЗДТГ, НЗХГ, НХОГ ОНӨААТҮГ, НӨХГ, дүүргүүдийн ЗДТГ, холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.






Аудитын мэдээлэл:

Ерөнхий мэдээлэл:

Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор 2016-2023 онд нийт 489,608.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 TAX, ""Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоол, "МУЗГ-ын 2015 оны 309, 458 дугаар тогтоол"-оор 132.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 5 TAX, БНХАУ-ын ЗГ-аас Монгол Улсын Засгийн газарт олгох "Нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашиглах тухай" зээлийн ерөнхий хэлэлцээр, МУЗГ-ын 2018 оны 160 дугаар тогтоолоор 40.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1 TAX, гадаадын зээл тусламжаар 3,153.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 TAX-г хэрэгжүүлэхээр баталжээ.

Ерөнхий мэдээлэл:

Тус TAX-үүдээс 87.2% буюу 281,700.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 TAX, гадаадын зээлийн хөрөнгөөр 172.8 сая ам долларын төсөвт өртөгтэй 6 TAX, 3,153.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 TAX, нийт 34 TAX-г хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, 207,908.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 TAX нь МУЗГ, ИТХ-ын тогтоол болон ЗД-ын захирамжаар хүчингүй болсон буюу хэрэгжээгүй байна.





Аудитын явцад гарсан хүндрэл, бэрхшээл:

Хүндрэл, бэрхшээл:

Аудитаар холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийхэд 2016-2023 онуудад хэрэгжүүлсэн ТАХ-ний үр нөлөөг тооцоолсон судалгаа байхгүй, хөдөлгөөний эрчмийг тодорхой бүсэд гараар тоолдог, шинээр ашиглалтад орсон гүүр, гүүрэн байгууламжуудад зөвхөн зөрчил илрүүлдэг хяналтын камеруудыг суурилуулсан зэрэг хүндрэл бэрхшээл илэрсэн. Энэ нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцоолох боломжийг хязгаарлаж байна.

Хүндрэл, бэрхшээл:

Гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцтай холбоотой нэгдсэн, бодит тоон мэдээллийг гаргаж авахын тул аудитын баг нийслэл, дүүргийн ИТХ-ын 2016-2023 оны нийт тогтоолыг бүрэн түүвэрлэж ажилласан. Үүнд 489,608.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ, ""Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоол, "МУЗГ-ын 2015 оны 309, 458 дугаар тогтоол"-оор 132.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 5 ТАХ, БНХАУ-ын ЗГ-аас Монгол Улсын Засгийн газарт олгох "Нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашиглах тухай" зээлийн ерөнхий хэлэлцээр, МУЗГ-ын 2018 оны 160 дугаар тогтоолоор 40.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1 ТАХ, гадаадын зээлээр 3,153.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.



2.2 Аудитын дүн:

Аудитын дэд зорилт

А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?

Хариулт: Нийслэлд 2016-2023 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-нүүдийг хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны баримт бичигт уялдуулан төлөвлөсөн байна.

А.2. Төсөл, арга хэмжээг Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөсөн үү?

Хариулт: Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 25.6% нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцээгүй байна.

Аудитын дэд зорилт

А.3. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцсон уу?

Хариулт: Төсөл, арга хэмжээ нь үр нөлөөтэй өгч байгаа хэдий ч төлөвлөхдөө эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцохгүй байна.

А.4. Төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн болон холбогдох стандартын шаардлагын дагуу төлөвлөгдсөн үү?

Хариулт: Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө холбогдох стандартуудад нийцүүлсэн хэдий ч хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Аудитын дэд зорилт

Б.1. Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулсан уу?

Хариулт: ХАА-г зохион байгуулахдаа холбогдох хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

Б.2 Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан уу? Нэмэлт гэрээ нь хуульд нийцсэн үү?

Хариулт: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г эхлүүлснээс гэрээг олон удаа сунгах, төсвийг жил бүр хуваан батлах шалтгаан болсон байна.



2.2 Аудитын дүн:

Аудитын дэд зорилт

Б.3. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан уу?

Хариулт: Төсөвлөлтийн шаардлага хангахгүй ТАХ-г төлөвлөснөөс ТАХ удаашрах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулах үндэслэл болжээ.

Б.4. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу?

Хариулт: Хяналтыг эрх бүхий байгууллага үр дүнтэй хэрэгжүүлсэн ч холбогдох эрхийн зүйн актыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.



Аудитын дэд зорилт

Б.5. Төсвийн хөрөнгө оруулалта ар хэрэгжсэн гүүр, гүүрэн байгу уламж, нүхэн гарцын хөрөнгийг бүртгэлжүүлж, ашиглалт, хамга алалтыг эзэнжүүлсэн үү?

Хариулт: Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, өмчид бүртгэх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын ажил бүрэн хэрэгжихгүй байна.



Гадаадын зээлийн хөрөнгөөр...



3,209.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй **1** TAX



151.6 сая ам.долларын гэрээний үнийн дүнтэй **6** TAX





Дотоод эх үүсвэрээс ...



Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам 1.0 км / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/

Гэрээний үнийн дүн: 1,395.5 сая төгрөг

Гүйцэтгэгч: Заабар ХХК



Наадамчдын гудамж, Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих ажил

Гэрээний үнийн дүн: 1,798.7 сая төгрөг


Гүйцэтгэгч: Туулын гүүр далай ХХК



Хайлаастын уулзвараас Дарь эхийн зам хүртэл 1.4 км зам 57 у/м гүүрийн хамт /Гадна тойруугийн хойд хэсгийн замын 3-р хэсэг/

Гэрээний үнийн дүн: 6,353.4 сая төгрөг

Гүйцэтгэгч: Мотор Сервис ХХК



Орбитын уулзвараас Толгойтын эцэс Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх авто замын өргөтгөл шинэчлэл /3.6 км/

Гэрээний үнийн дүн: 14,462.7 сая төгрөг

Гүйцэтгэгч: Тотал инж ХХК



Тахилтын авто замаас Авто цогцолбор хүртэлх 1.5 км авто зам, төмөр зам доогуур нүхэн гарцын хамт /СХД/

Гэрээний үнийн дүн: 5,918.9 сая төгрөг

Гүйцэтгэгч: Туулын гүүр далай ХХК



Явган хүнд зориулсан гүүрэн гарц /Их тойруу, Токиогийн гудамж, Дарь эхийн гудамжны уулзварын зүүн талд 48 дугаар сургуулийн хойно/

Гэрээний үнийн дүн: 847.8 сая төгрөг

Гүйцэтгэгч: ЗМЗ ХХК



271,046.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 27 ТАХ



8





Хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан ...

№.	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Гэрээний				Гүйцэтгэгч
			Үнийн дүн /Доллар/	Үнийн дүн /төгрөг/	Ажил гүйцэтгэх хугацаа		
					Эхлэх огноо	Дуусах огноо	
1	Замын Цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл	Гадаад	35,692,956.00	-	2017.06.01	2022.12.30	Хятадын төмөр замын 20-р товчоо групп
2	Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл /БНХАУ/	Гадаад	30,260,333.00	-	2015.05.08	2019.12.04	Хятадын төмөр замын 20-р товчоо групп
3	Гацууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэл 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн төсөл /БНХАУ/	Гадаад	36,537,306.35	-	2019.05.01	2022.06.30	Синохайдро корпрешн Монголиа ХХК
4	Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон сонсголонгийн 289.4 у/м төмөрбетон гүүр барих төсөл /БНХАУ/	Гадаад	13,855,128.92	-	2018.05.21	2021.12.31	Бээжин юни констракш групп монголий
5	Хайлаастын уулзвараас Дарь эхийн зам хүртэл 1.4 км зам 57 у/м гүүрийн хамт /Гадна тойруугийн хойд хэсгийн замын 3-р хэсэг/	НТХО	-	6,353,399,881.00	2017.08.01	2018.10.30	Мотор Сервис ХХК
6	Явган хүнд зориулсан гүүрэн гарц /Их тойруу, Токиогийн гудамж, Дарь эхийн гудамжны уулзварын зүүн талд 48 дугаар сургуулийн хойно/	НТХО	-	847,810,038.00	2017.04.13	2017.08.31	ЗМЗ ХХК
7	Ахмадын хорооллын орчмын Нарны зам, Дүнжингаравын авто замыг холбосон төмөр зам доогуурх явган зорчигч, автомашинд зориулсан нүхэн гарц, авто зам /БЗД/	НТХО	-	3,070,403,498.00	2020.02.14	2020.09.30	Мотор сервис ХХК болон Алтай рөүд ХХК түншлэл
8	Жанжин клубын орчмын төмөр зам доогуурх явган зорчигч болон автомашинд зориулсан нүхэн гарц, авто зам /БЗД, / дугаар хороо	НТХО	-	2,140,954,518.00	1/2/2020	10/30/2020	"Туулын Гүүр Далай" ХХК
9	Тахилтын авто замаас Авто цогцолбор хүртэлх 1.5 км авто зам, төмөр зам доогуур нүхэн гарцын хамт /СХД/	НТХО	-	5,918,886,858.00	2020.04.03	2020.10.29	Туулын гүүр далай ХХК
10	Шувуун фабрик- Сонгино чиглэлийн авто замын Туул гол дээрх 256 у/м төмөрбетон гүүрийн их засварын ажил /ХУД, 12 дугаар хороо /	НТХО	-	6,966,569,605.00	2020.08.28	2021.10.15	ЗМЗ ХХК
11	Авто зам, гүүрийн ажил /СБД, 15, 16 дугаар хороо/	НТХО	-	3,970,178,697.00	2020.05.08	2023.10.30	Ди Вай Кэй Би ХХК
12	Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, замын байгууламж	НТХО	-	84,114,133,535.00	2022.12.22	2023.12.31	Монгол зам групп ХХК
13	Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, гүүрийн барилга	НТХО	-	77,829,712,146.00	2022.05.20	2023.10.01	Мотор сервис ХХК түншлэл
14	Зайсангийн төмөр бетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлт	НТХО	-	26,215,990,083.00	2022.06.22	2023.11.01	ЗМЗ ХХК
15	Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3 у/м төмөрбетон гүүрийн барилга	НТХО	-	14,199,883,765.00	2022.04.28	2023.12.30	Ди Вай Кэй Би ХХК
16	Чингисийн өргөн чөлөөнөөс Баруун үйлдвэрийн гудамж хүртэлх авто зам, гүүрийн барилга	НТХО	-	5,989,599,364.00	2022.04.20	2024.12.30	Тотал Инж ХХК
17	Дунд голын гүүрийн барилгын ажил /Улаанбаатар хот, ХУД, 2 дугаар хороо/	НТХО	-	2,466,645,105.00	2023.02.06	2023.06.30	Гангүүр ХХК
18	Сонсголонгийн 289.4 у.м төмөрбетон гүүрийг шинээр барих	Гадаад	4,343,056.82	-	2018.04.18		Гангүүр ХХК
19	Орбитын уулзвараас Толгойтын эцэс Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх авто замын өргөтгөл шинэчлэл /3.6 км/	НТХО	-	14,462,697,600.00	2016.05.30	2016.12.01	Тотал инж ХХК
20	Баянгол дүүргийн 1 дүгээр хороо Алтай хотхоны хорооллын доторх авто замыг дунд голын авто замтай холбох гүүр барих	НТХО	-	1,488,202,503.00	2016.04.14	2016.09.15	Ди Вай Кей Би ХХК
21	Бэлхийн 18 у/м төмөрбетон гүүрийг буулгаж, шинээр барих, гүүр барих ажил /Сүхбаатар дүүрэг, 16, 18 дугаар хороо/, НАЗХ/2018/А/604-1 /түлхүүр гардуулах/	НТХО	-	852,200,000.00	2018.08.01	2018.11.15	УБЗЗАГ ОНӨААТҮГ
22	Жалганы төмөр бетон гүүр, 30 у/м /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 15 дугаар хороо, Жаргалантын 47 дугаар гудамж/	УТХО	-	948,718,203.00	2019.07.05	2019.10.30	Мотор сервис ХХК
23	Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам 1.0 км / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	НТХО	-	1,395,468,174.00	2020.07.10	2021.10.29	Заабар ХХК
24	16. "СХД-ийн жишиг нэгдсэн эмнэлгийн нэмэлт зам, гүүр, зогсоолын барилга угсралтын ажил"	УТХО	-	2,484,693,244.00	2020.03.09	2021.02.28	ЗМЗ ХХК
25	Наадамчдын гудамж, Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих ажил	ДТХО	-	1,798,659,612.00	2021.08.27	2022.08.26	Туулын гүүр далай ХХК
26	Дамбадаржаагийн уулзвар-Шарга морьтын төмөрбетон гүүр-Хандгайт чиглэлийн 16.35 км авто замын өргөтгөл, шинэчлэлт /2х50у/м гүүр/	НТХО	-	2,105,374,906.00	2015.06.13	2015.10.30	"Мотор сервис"ХХК
27	Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төсөл	Гадаад	30,940,000.00	-	2022.09.30	2024.11.30	Чайна Тисижу Сивил Инженеринг Групп ХХК
28	Сэлбэ дэд төвд баригдах 24 метр, 30 метр, 60 метр урттай гурван ширхэг төмөрбетон гүүрийн барилга угсралтын ажил	Гадаад	-	3,209,339,472.12	10/15/2018	6/30/2020	"ЗМЗ"ХХК
29	19 дүгээр хороо, Санзайн зуслангийн авто машин, явган хүний гүүр /Ойн булагт/	ДТХО	-	151,958,650	2023.05.31	2023.06.29	Ньюсиндкат ххк
30	18 дугаар хороо, Бэлхийн 46 дугаар гудамжийг Гүнжийн гудамжтай холбосон гүүр, байгууламж барих	ДТХО	-	197,929,880	2023.05.29	2023.06.27	Өсөн үржих констракшн ххк
31	Алтай хотхон Нарны хорооллын дундах төв авто зам дээгүүрх явган хүний гүүрэн гарц /24, 26 дугаар хороо/	ДТХО	-	1,198,150,831.00	2023.06.15	2023.11.30	энх бизнес өгөөмж ХХК
32	224-р цэцэрлэгийн орчмын авто гүүр барих /7 дугаар хороо/	ДТХО	-	598,372,237.0	2016.08.24	2016.10.07	Төгс зам ХХК
33	0.87 км хөлийн голын авто зам, гүүрэн байгууламжийн ажил /БЗД, 11 дүгээр хороо/	ДТХО	-	2,810,543,897.00	2023.10.27	2024.09.30	Чанар хийц ХХК
34	Сэлбэ голын явган хүний гүүр, тохижилтын ажил (БЗД, 43 дугаар хороо)	НТХО	-	469,715,382.00	2023.06.01	2023.07.30	Дэд бүтэц консалт ХХК
			151,628,781.09	274,256,191,684.12			



2.3 Аудитын гол дүгнэлт:

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд



1. Төсөл, арга хэмжээнүүд нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан ч 41% нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцоогүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна;



2. Шинээр ашиглалтад орсон автозамын гүүр, гүүрэн байгууламжид зөвхөн зөрчил илрүүлдэг хяналтын камеруудыг суурилуулсан, хөдөлгөөний эрчмийг тодорхой бүсэд гараар тоолдог зэрэг нь төсөл, арга хэмжээний хүрсэн үр дүнг бүрэн тооцох нөхцөлийг хязгаарлаж байна;



3. Хуульд заасан шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг, архивын нэгжийн хадгалалт хамгаалалт хангалтгүй зэрэг зөрчил илэрсээр байгаад анхаарч холбогдох эрх зүйн актыг мөрдөж ажиллах шаардлагатай байна;



4. Зураг төсөвгүй, газар чөлөөлөлт хийгдээгүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулах үндэслэл болж байна.



5. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, өмчид бүртгэх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын ажил бүрэн хэрэгжихгүй байна.





2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил, дутагдлын нэгтгэл

№	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан	Тоо	Дүн	Үүнээс			
				Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
1.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д:	4	-	4	-	-	-



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ



Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д:

1. Төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө хуульд заасан төсөвлөлтийн шаардлагуудыг хангуулж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг бүрэн тооцоолж байх;
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуульд заасан шаардлагыг хангасан гүйцэтгэгч сонгон шалгаруулах, архивын нэгжийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах;

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д:

3. Чиг үүргийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, автозамын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцын нэгдсэн мэдээллийн сантай болох, өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж ажиллах;
4. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулахдаа олон улсын жишигт нийцүүлэн техник тоног төхөөрөмжийг тусгаж зураг төсвийг боловсруулах.



Анхаарал хандуулсанд баярлалаа

